



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/406

Улаанбаатар хот

Заавар батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 8 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сум, галт хэрэгсэлтэй харьцах үеийн заавар”-ыг нэгдүгээр, “Сум, галт хэрэгслийн дуудлагаар ажилласан тухай нотломж”-ийг хоёрдугаар, “Бутлагч тэсрэх бодисын тусгай шифр тэмдэглэгээ”-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааврыг мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажиллагааны удирдлагын газар (хурандаа Б.Баянмөнх)-т даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН



СУМ, ГАЛТ ХЭРЭГСЭЛТЭЙ ХАРЬЦАХ ҮЕИЙН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь тэсэрч дэлбэрээгүй сум, галт хэрэгслийн холбогдолтой дуудлага, мэдээллийн дагуу голомтод хүрэлцэн очих, нөхцөл байдлыг үнэлэх, аюулгүйн бүсийг тогтоох, мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, харилцан ажиллагааг зохион байгуулах, ажиллагааны үед аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1.2. Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа их буу, миномёт, тийрэлтэт артиллери, хуягт, зенит, танкны сум, минийн заалт бичиглэл, түүний зарим тайлбарыг энэхүү зааварт тусгав.

1.3. Зааврыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, анги, салбар, нэгжүүд дагаж мөрдөнө.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ зааварт хэрэглэсэн нэр, томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:

2.1.1. “Тэсэрч дэлбэрэх зүйл” гэж гадны хүчний үйлчлэлээр агшин зуурын хугацаанд тэсэрч хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хор хөнөөл учруулах аюултай химийн нэгдэл буюу механик хольц, их буу, миномётын мина, нисэх онгоцны бөмбөг, пуужин, гранат, буудлагын зэвсгийн сум, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, мина, зарим төрлийн хүчтэй пиротехникийн хэрэгслийг;

2.1.2. “Сум галт хэрэгслийн дуудлагын маршрут” гэж сум, галт хэрэгслийн дуудлагын дагуу эрэн хайх, аврах бүлгийн тухайн цэг рүү очих замыг;

2.1.3. “Аюулгүйн бүс” гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тэсрэлтийн үйлчлэл (тэсрэлтийн улмаас шидэгдэх эд материал, шороо чулуулаг, цохих долгион) хүн, техник тоног төхөөрөмж, барилга байгууламжид нөлөөлөхгүй байх зааг, хүрээг;

Гурав. Сум, галт хэрэгсэлтэй харьцах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

3.1. Бүлгийн дарга (Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч)

3.1.1. Ослын голомт руу хөдөлгөөн үйлдэхээс өмнө ахлах тэсэлгээчин, эмнэлгийн зааварлагчийг томилох;

3.1.2. Тэсрээгүй үлдсэн сум, галт хэрэгслийг илрүүлэх, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг хэрэгжүүлэх, хяналт тавих;

3.1.3. Тэсрээгүй үлдсэн сум, галт хэрэгслийн аюултай хамгийн бага болон холын зайг тодорхойлох;

3.1.4. Сум, галт хэрэгслийн төрөл, загвараас хамааран аюулгүйн бүсийг тогтоох;

3.1.5. Сумны их бие, хонгио, хайрцаг, савлалтын хэрэгсэл, тэсрүүлэгч, цэнэг, мина, гранат дээрх бичиглэл тамга, тэмдэг, товчилсон үг, үсэг загварыг сайтар мэдэж галт хэрэгслийн нэр төрөл зориулалтыг тодорхойлох;

3.1.6. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн алба хаагчийг ажиллагаанд оролцуулахгүй байх;

3.2. Ахлах тэсэлгээчин

3.2.1. Бүлгийн даргыг тогтмол мэдээллээр хангаж ажиллах;

3.2.2. Бүлгийн даргын өгсөн үүргийн дагуу ослын голомтод аврах ажиллагааг зохион байгуулах;

3.2.3. Бүлгийн дарга байхгүй тохиолдолд бүлгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.3. Аврагч-тэсэлгээчин

3.3.1. Бүлгийн даргын өгсөн үүргийн дагуу ажиллах;

3.3.2. Сум, галт хэрэгслийн аюулгүйн бүсийг тогтоох;

3.3.3. Шаардлагатай туг, дарцаг, хаалтыг аюултай бүс рүү гадны хөдөлгөөн нэвтэрч болзошгүй газар байрлуулах;

3.3.4. Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх;

3.3.5. Болзошгүй аюулаас өөрийгөө болон нөхдийгөө урьдчилан сэргийлэх аюулгүй байдлаа хангах;

3.4. Аврагч-тэсэлгээчин нохой хөтлөгч

3.4.1. Албаны нохойн тоног, хэрэгслийг бүрэн өмсүүлж хэвшүүлэх;

3.4.2. Ослын голомтын бүсэд очоод 15-20 минутын хугацаанд нохойг орчинд нь дасгах;

3.4.3. Албаны нохойгоор тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг эрж хайлгах, өөрийн болон нохойны аюулгүй байдлыг хангах;

3.4.4. Бүлгийн даргатай эрлийн ажиллагааны мэдээллийг тогтмол солилцох;

3.4.5. Эрэл гүйцэтгэх явцад эрэлч нохойн "ээрэг" дохио үзүүлж буй цэгт тэмдэглэгээ хийж, бүлгийн даргад илтгэх;

3.4.6. Тэсэрч дэлбэрэх зүйлийг хайн илрүүлэх, сум, галт хэрэгслийн үүрэг зориулалт, тактик техникийн өгөгдөхүүн, ажиллах зарчмыг тодорхойлох;

3.4.7. Тэсрээгүй үлдсэн сум, галт хэрэгслийн хамгийн бага болон холын зайг тодорхойлоход бүлгийн даргад туслах;

3.4.8. Тэмдэглэсэн цэг буюу тэсрэх сум, галт хэрэгсэл илрүүлсэн цэгээс 25-50 метрийн зайд нохойг авч гаран урамшуулах;

3.5. Аврагч-жолооч, холбоочин

3.5.1. Тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд гарсан гэмтлийг засварлах бэлтгэл бэлэн байдлыг хангах;

3.5.2. Үүрэг гүйцэтгэхдээ холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хариуцах;

3.5.3. Газар орны нөхцөлд тохируулан холбоо барих цэгийг тодорхойлж, холбооны техник хэрэгслийг дэлгэн байгуулах;

3.5.4. Тэсрээгүй үлдсэн сум, галт хэрэгслийн талаар мэдээ, мэдээллийг тогтоосон цагуудад шуурхай удирдлагын зохицуулагч дээд шатны байгууллагад дамжуулах;

3.5.5. Бүлгийн даргын зөвшөөрөлгүй автомашиныг байрнаас нь хөдөлгөхгүй байх;

3.5.6. Аврагч-жолооч дуудлагаар гарахдаа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг чанд мөрдөж, техникийн аюулгүй байдлаа ханган замын хөдөлгөөнд оролцох;

3.6. Эмнэлгийн зааварлагч

3.6.1. Эмнэлгийн зааварлагчаар мэргэжлийн сургалтад хамрагдсан алба хаагчийг томилно;

3.6.2. Эрэн хайх, аврах бүлгийн алба хаагчдын эрүүл мэндэд үүсэж болох гэмтлийн талаар ойлголт өгөх;

3.6.3. Аврагч тэсэлгээчний артерийн даралт, захын судасны цохилт, арьсны бүрэн бүтэн байдал, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах;

3.6.4. Шаардлагатай үед бүлгийн бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, анхны тусламж үзүүлэх;

3.6.5. Шаардлагатай үед нэрвэгдэгсдийг лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллага руу тээвэрлэх;

3.6.6. Ажиллагааны үед яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслээр хангах;

Дөрөв. Сум, галт хэрэгслийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, хүрэлцэн очих

4.1. Сум, галт хэрэгслийн дуудлагыг хүлээн авсан дуудлага хүлээн авагч дараах мэдээллийг бүрдүүлнэ. Үүнд:

4.1.1. Дуудлагын талаарх товч мэдээлэл;

4.1.2. Мэдээлэл өгөгчийн нэр, хаяг, утасны дугаар;

4.1.3. Тэсрээгүй үлдсэн сум, галт хэрэгслийн талаарх мэдээлэл (байршил, огноо, цаг, минут);

4.1.4. Тэсрээгүй сум, галт хэрэгсэл олдсон газарт хүрэлцэн очих зам, маршрут;

4.2. Дуудлага хүлээн авсан төв, орон нутгийн Онцгой байдлын анги, салбар нь дараах ажиллагааг явуулна. Үүнд:

4.2.1. Мэдээллийг нягтлан шалгах;

4.2.2. Сум, галт хэрэгсэл олдсон газрыг байр зүйн зураг болон байршил тогтоогч (GPS)-д тэмдэглэх;

4.2.3. Шаардлагатай мэдээллийг цуглуулах;

4.2.4. Эрэн хайх, аврах нэгжийг томилгох;

4.2.5. Сум, галт хэрэгсэл олдсон газарт шуурхай хүрэлцэн очих зам, маршрутыг тогтоох;

4.3. Сум, галт хэрэгсэлтэй харьцах бүлэг нь дараах үйл ажиллагааг явуулна.

Үүнд:

4.3.1. Сум, галт хэрэгслийн дуудлагаар очсон бүлгийн дарга газар орныг судлах;

4.3.2. Тэсрээгүй үлдсэн сум, галт хэрэгсэл илэрсэн буюу осол эндэгдэл гарсан тухай дуудлага авмагц уг тэсэрч, дэлбэрэх зүйлийн байгаа байршил, төрөл хэмжээ, учирсан болон учруулж болзошгүй аюулыг тогтоох;

4.3.3. Сум, галт хэрэгслийг хайж олох, аюулгүйн бүсийг тогтоох;

4.3.4. Сум, галт хэрэгслийн тактик техникийн өгөгдөхүүн, төрөл, загвар, аюулгүйн бүсийг тогтооход алба хаагчид сахилга бат, дэг журмыг баримтлах;

4.3.5. Аюултай бүсээс хүн, мал, амьтныг татан гаргах, холдуулах ажиллагааг зохион байгуулах

4.3.6. Шуурхай удирдлагын зохицуулагч, холбогдох албан тушаалтанд мэдээллийг тогтмол дамжуулах, хүлээн авах;

4.3.7. Сум, галт хэрэгслийн аюулгүйн бүсийг тогтоосны дараа цагдаагийн байгууллагад ослын голомтын хамгаалалт авах газрыг шилжүүлэх, хамтран ажиллах;

4.3.8. Тэсрээгүй үлдсэн сум, галт хэрэгсэл олдсон талаар төв, орон нутгийн Засаг дарга, цэргийн штаб, цэргийн анги, байгууллага, Зэвсэгт хүчний жанжин штабт мэдэгдэх;

4.3.9. Зэвсэгт хүчний анги, байгууллагаас ирсэн хими, инженерийн бүлэгтэй хамтран ажиллах, тэсрээгүй сум, галт хэрэгслийг хүлээлгэн өгөх;

4.3.10. Ажиллагааны тэмдэглэл хөтлөх;

4.3.11. Ажиллагааг дуусгах.

4.3.12. Ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид үзлэг хийж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган голомтоос байнгын байрлал руу хөдөлгөөн үйлдэх;

4.3.13. Эрэн хайх, аврах ажиллагааны талаар илтгэх хуудас, тайлан, нотломж үйлдэх;

4.3.14. Дараагийн ажиллагааны бэлэн байдлыг хангах;

**Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн дүрмийг мөрдөх ажиллагаа**

5.1. Сум, галт хэрэгслийн дуудлага хүлээн авмагц аврах бүлгийн дарга, ахлах даргын өгсөн үүргийн дагуу бүлгийн бие бүрэлдэхүүний нэг бүрийн хамгаалах хувцас, хэрэгсэл, тусгай зориулалтын багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд үзлэг, шалгалт хийж бэлэн байдлыг хангах;

5.1.1. Бие бүрэлдэхүүнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулах;

5.1.2. Голомтод очсон бүлэг сонор сэрэмжтэй байж тогтоосон тэмдэг тэмдэглэгээний дотуур явахыг эрс хориглох;

5.1.3. Тамхи татах, ил гал гаргахыг хатуу хориглох;

5.1.4. Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдах, ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар зөрчигдөж болзошгүй болон зөрчигдсөн тохиолдолд аврах ажиллагааны удирдагчид мэдэгдэж арга хэмжээ авах;

5.1.5. Аврагч бүр хүн нэг бүрийн тусгай зориулалтын хамгаалах хувцас бээлий, нүдний шил, дуулга (каска) зэргийг сум, галт хэрэгсэлтэй харьцах үед өмсөж зүүсэн байх;

5.1.6. Ажиллагааны удирдагчийн зөвшөөрөлгүй сум, галт хэрэгслийн голомтыг орхиж явах, сум, галт хэрэгсэлд хүрэх, ойртохгүй байх;

5.1.7. Замын нөхцөл байдалд дүгнэлт хийж анхаарал болгоомжтой явах;

5.1.8. Аврах ажиллагааны автомашиныг бусад хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байрлуулж, тэдгээрийн байршлыг тогтоож тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах;

**Зургаа. Сум, галт хэрэгсэлтэй харьцах алба хаагчдын үүрэг,
тавигдах шаардлага**

6.1.1. Сум, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх зүйл, мина, гар хийцийн тэсрэх бөмбөгийг хайн илрүүлэх багаж хэрэгслийн үүрэг зориулалт, тактик техникийн өгөгдөхүүн, иж бүрдэл ажиллах зарчмыг мэддэг байх;

6.1.2. Тэсрээгүй үлдсэн сум, галт хэрэгслийн аюултай хамгийн бага болон холын зайг мэддэг байх;

6.1.3. Тусгай зориулалтын техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эзэмшиж дадлагажсан байх;


6.1.4. Сум галт хэрэгслийн дуудлагаар явах алба хаагчид нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах сургалтад хамрагдсан байх;

Долоо. Хяналт, хариуцлага

7.1.1. “Сум, галт хэрэгсэлтэй харьцах үеийн заавар”-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн хэрэгжилтэд төв, орон нутгийн эрэн хайх, аврах анги, салбар, бүлгийн дарга нар хяналт тавина.

7.1.2. Энэхүү зааврыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Нэг. Сум, галт хэрэгслийн дуудлагаар ажилласан тухай нотломж №

.....
/хэний тушаал, захирамжаар/
Бүлгийн дарга
/албан тушаал, цол, овог нэр/

Бүлгийн гишүүд.....
.....
.....бүрэлдэхүүнтэй бид
/ албан тушаал, цол, овог нэр/

(тэсэрч, дэлбэрэх аюул бүхий зүйлийг илрүүлсэн он, сар, өдөр, албан байгуулга, албан тушаалтан, иргэний нэр хаяг, харилцах утас, тэсэрч, дэлбэрэх аюул бүхий зүйл олдсон газар, нутаг дэвсгэр, барилга байшин)

(мэдээллийн мөрөөр хэн, хэзээ, ямар арга хэмжээ авсан)

Илэрсэн зүйлийн зориулалт, үйлдвэрлэсэн он, тоо хэмжээ, төрөл, чанар байдал

д/д	Сум, галт хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зориулалт	Үйлдвэрлэсэн он	Тайлбар /төрөл хамаарал, чанар байдлын талаар дэлгэрэнгүй бичнэ/
1						
2						
3						
4						

Илэрсэн зүйлийг 2023 оны дугаар сарын ... өдөр аюулгүй ажиллагааны зааврын дагуу

(хүлээлгэн өгсөн, илэрсэн зүйлийг хурааж авсан, аюулгүй болгосон талаар авсан арга хэмжээ)

Цаашид авах арга хэмжээ, анхаарах асуудлын талаарх санал дүгнэлт:

(шаардлагатай бол гэрэл зураг, дүрс бичлэг, бүдүүвч зураглал болон бусад материалыг баримт болгон хавсаргаж болно)

Нотломжийг.....хувь үйлдэв.

- 1 дүгээр хувийг.....
- 2 дугаар хувийг.....
- 3 дугаар хувийг.....

Сум, галт хэрэгслийг хүлээлгэн өгсөн бүлгийн дарга

.....
.....
.....

/албан тушаал, цол, овог нэр, гарын үсэг/

Сум, галт хэрэгслийг хүлээлгэн өгсөн бүлгийн гишүүд

.....
.....
.....

/албан тушаал, цол, овог нэр, гарын үсэг/

Аюулгүйн бүс тогтооход байсан албан тушаалтан

.....
.....
.....

(цагдаа, тагнуул, орон нутгийн засаг захиргааны байгууллагын албан тушаалтны албан тушаал, цол, овог нэр, гарын үсэг)

Хоёр. Урьдчилсан зааварчилгааны хүснэгт

Хүснэгт-1

2023 оны дугаар сарын-ны өдөр

д/д	Цол	Овог нэр	Зааварчилгааны утга	Хугацаа	Зааварчилгааг баталгаажуулсан албан хаагчийн / цол, албан тушаал/ гарын үсэг	Зааварчилгаа авсан хүний гарын үсэг

ЗААВАРЧИЛГАА ӨГСӨН:
БҮЛГИЙН ДАРГА,
АХЛАХ ДЭСЛЭГЧ

Б.БАТ

Гурав. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хамгийн бага аюулгүйн зай

Хүснэгт-2

д/д	Тэсрэх аюул бүхий зүйлийн нэр	Тротилийн жин	Аюулгүйн зай /м/	
			Барилга, байшин	Ил талбайд байгаа хүн
1	Гар гранат РГД-5	-	-	50
2	Гар гранат Ф-1	-	-	200
3	Тротилийн шашек	0,2	-	45
4	Тротилийн шашек	0,4	-	55
5	0,33 литрийн багтаамжтай лаазанд савласан цэнэг	-	-	60
6	Явган цэрэг эсэргүүцэх минүүд	0,75-0,2	-	150
7	Танк эсэргүүцэх минүүд	4,8-11	-	500
8	105 мм хүртэлх калибрын сум	-	-	300
9	105 мм-ээс дээш калибрын сум	-	-	600

10	Онгоцны бөмбөг	-	-	800
11	Труба хоолойд суулгасан гар хийцийн бөмбөг	2,3	25	260
12	Бүсэнд зүүсэн дэлбэрэх цэнэг	4,5	30	330
13	Хантаазанд нуусан дэлбэрэх цэнэг	9	35	415
14	Гар цүнхэнд нуусан дэлбэрэх цэнэг	23	50	570
15	Чемоданд нуусан дэлбэрэх цэнэг	-	-	350
16	Суудлын автомашинд ачсан дэлбэрэх цэнэг	227	100	457
17	Жийп загварын суудлын автомашинд ачсан дэлбэрэх цэнэг	454	130	540
18	Микроавтобусанд ачсан дэлбэрэх цэнэг	-	-	920
19	5 тн-ын даацтай ачааны автомашинд ачсан дэлбэрэх цэнэг	4536	270	1150
20	10-15 тн-ын даацтай ачааны автомашинд ачсан дэлбэрэх цэнэг	13608	380	1990
21	Трайллерт ачааны автомашинд ачсан дэлбэрэх цэнэг	27216	480	2140

Дөрөв. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ойж болох холын зай

Хүснэгт-3

д/д	Төрөл загвар	Калибр /мм/	Бутарсан хэсгүүдийн ойж болох холын зай /м/
1	Их буу, миномётын сум, мина	37-76	500
		76-105	700
		105-150	850
		200-300	1200
2	Нисэх онгоцны бөмбөг	25-50	850
		100	1000
		250	1200
		1000	1500
		2000	1700
		5000	2000
3	Танк эсэргүүцэх минүүд	-	500
4	Явган цэрэг эсэргүүцэх минүүд	-	500

Тав. Их бууны сум, галт хэрэгслийн будагны төрөл

5.1.1. Ялгах тэмдэг сумны хошууны дээд төвлөрүүлэгчийн доорх "ялгах будаг" өнгөт бүс нь:



- Улаан бүс - шатаагч
- Цэнхэр бүс - бетон цөмлөгч
- Цагаан бүс – гэрэлтүүлэгч
- Хар бүс - утаат
- Шар бүс - химийн
- Бүх гадаргуу улаан – ухуулгын

- Бүх гадаргуу хар - дадлагын


5.1.2. Сумны хошууны доод төвлөрүүлэгч бүсний дээд талд хар өнгийн цагариг байвал сумны их биеийг гантай ширмээр хийснийг илтгэнэ.

5.1.3. Хонгио дээрх загварын дээд талд хар өнгийн бүс байвал - хасмал цэнэгтэй сум гэж ойлгоно.

5.1.4. Асаах бялт дээр цагаан өнгийн зураас байвал бялтын их биеийг дахин ашигласныг илтгэнэ.




Зургаа. Их бууны галт хэрэглэлийн төрөл



Цэнэглэгч үйлдвэрийн
дугаар
Цэнэглэсэн бүлгийн
дугаар

Калибр
Жингийн тэмдэг



Тэсрэх бодисын
төрөл

Сумны хошууны заалт

Үйлдвэр
бүлэг
он



Калибр




Тэсрэх бодисын төрөл
Тэсрүүлэгчийн төрөл

Сумны товчилсон заалт



- Шидэгч цэнэгийн нэрэлбэр
- Цэнэгийн товчилсон заалт
- Их бууны системийн товчилсон нэрлэмж
- Дарины марк, бүлгийн дугаар, даринь бэлтгэсэн он ба үйлдвэр
- Буудалтын угсралтын тухай үйлдвэрийн өгөгдөхүүнүүд (бүлэг, он, бааз)
- Флегматизаторын шифр (тоо)



Долоо. Минийн төрөл, загвар

7.1.1 Минүүдийг зориулалтаар нь дараах байдлаар ангилна. Үүнд

-танк эсэргүүцэх:

-явган цэрэг эсэргүүцэх:

-тээврийн хэрэгсэл эсэргүүцэх:

-төхөөрөмж эвдэх:

- тусгай зориулалтын минүүд гэж ангилна.

7.1.2. Ажиллуулах аргаар нь минийг удирдлагатай удирдлагагүй гэж ялгана.

7.1.3. Удирдлагатай минүүдийг шаардлагатай мөчид удирдах байрнаас утас, радио холбоо буюу механик хэрэгслийн тусламжтайгаар тэсэлнэ.

7.1.4. Удирдлагагүй минүүд нь түүнд гадны нөлөө үйлчлэхэд (агшин зуур тэсрэх минүүд) буюу тэдгээрийг тавих үед тогтоосон хугацаа дуусмагц (удах тэсрэх минүүд) түргэн зуур дэлбэрнэ.

7.1.5. Минийн хийцээс хамааран тэдгээрт үйлчлэн дэлбэлэх гадны нөлөөнүүд нь даралт (даралтаас тэсрэх мина), утсыг татах буюу огтлох (таталтаас тэсрэх мина), минийн ачааг авах (ачааг авахад тэсрэх мин), тавьсан минийн орчны соронзон талбайн өөрчлөлт (соронзон мина), фотоэлемент дээр гэрэл тусах болон бусад арга нөлөөнүүд байж болно.



Ф-1



РГД-5




ПМН



ПМН-2



ПМД-6



ПОМЗ-2




ОМЗ-72

ОЗМ-4



МОИ-50



МОИ-100

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2023 оны 4 дугаар сарын 21 ны өдрийн
 А/406 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



НЭГ. Бутлагч тэсрэх бодисын тусгай шифр тэмдэглэгээ

№	Тэсрэх бодисын нэр	Шифр
1	Тротил	Т
2	Сульфиттай тротил	ТС
3	Гексоген	Г
4	Гексогентай тротил	ТГ-30
5	Гексогентай тротил	ТГ-50
6	Аммотол 80/20 80% аммоний селитр 20% тротил	А-80
7	Аммотол 40/60	АТ-40
8	Флегматизортой аммотол	АТФ-40
9	Шнейдерит	Ш

ХОЁР. Галт хэрэгслийн заалтад ордог үсгийн тайлбар

Үсэг	Тайлбар	Үсэг	Тайлбар
У	Угсармал сум	БП	Цоргигч эрэгдэг сум
В	Салангид цэнэглэдэг сум	БК	Цоргигч эрэгдэггүй сум
Ф	Дэлбэрдэг сум	Г	Бетон нэвтлэгч сум
О	Задардаг сум	Д	Утаат сум
ОФ	Задран дэлбэрдэг сум	З	Шатаагч сум
ОР	Задардаг гэрэлт зам гаргагч сум	С	Гэрэлтүүлэгч сум
ОЗР	Задардаг шатаагч гэрэлт зам гаргагч сум	А	Ухуулгын сум
БР	Хуяг нэвтлэгч гэрэлт зам гаргагч сум	ПБР	Практикийн хуяг нэвтлэгч гэрэлт зам гаргагч сум
ДЦ	Цель заагч утаат сум	Холостой	Хоосон сум
Дарин цэнэгийн заалт			
А	Хонгио руу хийхэд зориулагдсан ууттай цэнэг	Ж	Хонгиотой цэнэг
Б	Хонгионд тавихад зориулагдсан ууттай цэнэг	ЖН	Хонгиотой нитродигликол дарин цэнэг
ЖД	Хонгиотой нитроглицерин дарин цэнэг	ЖК	Хонгиотой нитроксилитан дарин цэнэг

ГУРАВ. Монгол Улсад хэрэглэгдэж байгаа зарим зэвсэглэл,
галт хэрэгслийн заалт

д/д	Зэвсэглэлийн нэр	Галт хэрэглэлийн заалт
1	23мм ЗУ-23-2 зенитийн буу	УОФ35, УОР1, БЗТ, УБР1
2	37мм АЗП-39 зенитийн буу	УОР-167, УБР-167
3	57мм С-60 зенитийн их буу	УОР-281, УБР-281
4	85мм Д-44 их буу	УО-365, УО-367, УБР-367, УБК1, УБК-367, УД-367
5	85мм Д-48 их буу	УОФ-372, УБР-372, УБК-372,
6	100мм БС-3 их буу 100мм Д10Т2 танкийн их буу	УОФ-412, УОФ-412У, УБР-412, УБК4, УД-412
7	100мм МТ-12 их буу	УОФ3, УБК2, УБМ1, УБМ2

8	122мм М-30 гаубиц	ВО-463, ВОФ-463, ВБП-463, ВБК1, ВД-463, ВС-463, ВА1
9	122мм Д-30 гаубиц	ВОФ5, ВПЗ, ВБКЗ, ВД2, ВСЗ, ВА2
10	130мм М-46 их буу	ВОФ-482, ВБР-482
11	152мм МЛ-20 их буу	ВОФ-545, ВБР-545
12	82мм БМ-37 миномёт	ВО-832, ВД-832, ВС-832
13	120мм ПМ-38 миномёт	ВОФ-843, ВД-843, ВС-843
14	160мм М-160 миномёт	ВОФ-853
15	140мм БМ-14 тийрэлтэт систем	М-14ОФ
16	122мм БМ-21 тийрэлтэт систем	М-21ОФ
17	73мм СПГ-9 суурьт гранатомёт	ПГ-9В, ОГ-9В
18	73мм 2А28 их буу	ПГ-15В, ОГ-15В
19	Танк эсэргүүцэх залуурт пуужин	9М14М

ДӨРӨВ. Артиллерийн зэвсэглэлд хэрэглэгдэж байгаа галт хэрэгслийн заалт

№	Зэвсэглэлийн нэр	Сум, мина төрөл
1	85 мм-ийн Пушек Д-48	Задран дэлбэрдэг УОФ-372
2	100 мм-ийн Пушек БС-3	412 гэсэн заалттай байна
3	122 мм-ийн Гаубиц М-30	задран дэлбэрдэг сум ОФ-462, 463
4	140 мм-ийн тийрэлтэт сум М-14	ОФ заалт 53-ОФ-949, тэсрэх бодис ТС-60
5	122 мм-ийн тийрэлтэт сум	М-21 ОФ, тэсрүүлэгч МРВ-У
6	120 мм-ийн миномёт	ОФ-843, ган ширмэн их биетэй задран дэлбэрдэг, ОФ 843А утаат, Д-843А, Д-5 шатаагч, З-843А гэрэлтүүлэгч, С843 тэсрүүлэгч ГМЗ-7, М-12, Т-1, М-5, М-6
7	160 мм-ийн миномёт	160 мм-ийн мина Ф-853
8	57 мм-ийн зенитийн С-60 Пушек	281 гэсэн заалттай. Задардаг сум УОР-281, хуяг нэвтлэгч УБР-281У, тэсрүүлэгч МГ-57, МГЗ-57, МД-10

ТАВ. Зэвсэгт хүчинд хэрэглэгдэж байгаа галт хэрэгслийн техникийн үзүүлэлт

Сумны нэр	Заалт	Хошууны жин	Тэсрүүлэгчийн төрөл	Асаах бялт	Дарь		Анхны хурд м/сек	Даринь даралт кг/см ²	Хайрцаг дахь сумны тоо	Сумны жин, кг
					Төрөл	Жин				
152 мм-ийн дүүрэн цэнэгтэй ОФ сум	ВОФ-5474	43.56	РГМ-2 В-429	КВ-5	ДГ-3 19/1 НДТ-3 19/1	10.9	770	2350	1	65.6
152 мм-ийн хасмал цэнэгтэй ОФ сум	ВОФ-5474	43.56	РГМ-2 В-429	КВ-5	4/1-12/1 ТР	3.54	500	2350	1	58.0
152 мм-ийн хуяг нэвтлэгч БР сум	ВБР-5476	48.96	ДБр	КВ-5	ДГ-3 19/1 НДТ-3 19/1	10.1	700	2350	1	70.2
152 мм-ийн хурц хошуутай хуяг нэвтлэгч БР сум	ВБР-547	48.78	МД-7	КВ-5	ДГ-3 19/1 НДТ-3 19/1	10.1	700	2350	1	70

152 мм-ийн дадлагын сум	ВПБр-547	48.78		КВ-5	ДГ-3 19/1 НДТ-3 19/1	10.1	700	2350	1	70
130 мм-ийн дүүрэн цэнэгтэй ОФ сум	ВОФ-482М	33.4	РГМ-2 В-429	КВ-5	ДГ-3 23/1 НДТ-3 23/1	12.9	930	3150	1	59.1
130 мм-ийн хасмал цэнэгтэй ОФ сум	ВОФ-482 МУ	33.4	ДБР	КВ-5	ДГ-3 23/1 НДТ-3 23/1	6.54	705	2700	1	51.8
130 мм-ийн хуяг нэвтлэгч БР сум	ВБР-482	33.4	ДБР	КВ-5	11	12.9	930	3150	1	59.1
122 мм-ийн задардаг сум	ВО – 463 А	21.76	РГМ-2Д-1-4	КВ-4	4/1 + 9/7	1.8	458	1960	2	74
122 мм-ийн дүүрэн цэнэгтэй ОФ	ВОФ – 463 М	21.76	РГМ-2Д-1-4	КВ-4	4/1 + 9/7	2.1	515	2350	2	75
122 мм-ийн төмөр цахиур хөтлөгч бүстэй ОФ	ВОФ - 463	21.76	РГМ-2Д-1-4	КВ-4	4/1 + 9/7	2.1	515	2350	2	75
100 мм – ийн цоргогч ажиллагааны сум	УБК2	10.0	ГПВ-2	КВ-5	ДГ-3 13/1	5.49	515	2350	23	75
85 мм – ийн дүүрэн цэнэгтэй ОР сум	УО-365к	9.54	МГ-НКТМ-19	КВ-4	12/1 ТР 9/7	4.9	785	2585	29	78
85 мм – ийн дүүрэн цэнэгтэй ОР сум	УО-367	9.54	В-429	КВ-4	12/1 ТР 9/7	4.9	785	2585	29	78
85 мм – ийн хасмал цэнэгтэй ОР сум	УБР-367	9.2	МГ-НКТМ-1У	КВ-4	12/1 ТР 9/7	3.8	625	2150	25	61
85 мм – ийн хуяг нэвтлэгч Бр сум	УБР-367П	11.72	ДБР-2МД-8	КВ-4	12/1 ТР 9/7	4.2	792	2585	29	78
85 мм – ийн хуяг подкалибрын сум	УОР-281	2.8	МД-8	КВ-4	12/1 ТР 9/7	4.2	792	2585	29	75
57 мм-ийн задардаг сум	УБР-281/у	2.8	МГ-57МГ3-57	КВ-5 КВ-13	11/7	0.9			6.6	49
57 мм-ийн хуяг нэвтлэгч сум			МД-10	КВ-5 КВ-13	11/7	0.9			6.6	79

ЗУРГАА. Танк эсэргүүцэх минүүдийн тактик техникийн үзүүлэлт

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	ТМ-57	ТМ-62М	ТМ-62П	ТМ-62Д	ТМК-2
1	Минийн жин Тэсрэх бодисын жин /кг/	9,0 6,5	9,5-10 7-7,5	9,0-11 6,6-8,0	11-13 5,8-11	12 Тортил-6, ТГ50-6,5
2	Тэсрүүлэгчийн төрөл	МВ3-57	МВЧ-62	МВЧ-62	МВЧ-62	МВК-2

3	Гадаргуугийн материал	Төмөр	Төмөр	Хуванцар	мод	Төмөр
4	Ажиллагаанд оруулах хүч /кг/с/	200-500	175-650	175-650	175-650	8-12
5	Диаметр	30	320	340	340x295	307

ДОЛОО. Явган цэрэг эсэргүүцэх минүүдийн тактик техникийн үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	ПМД-6М	ПМН	ПОМЗ-2М	ОЗМ-4	Мон-50	МОН-100	МОН-200
1	Минийн жин /гр/	490	550	1800	5000		5000	25000
2	Цэнэгийн жин /гр/	200	200	75	170		2000	12000
3	Ажиллуулах арга	Даралтаар		Таталтаар		Цахилгаанаар		
4	Ажиллуулах хүч /кг/	6-8	8-25	0,5-1,0				
5	Их биеийн материал	Мод	Хуванцар	Ширэм	Ширэм	Төмөр	Төмөр	Төмөр

---оОо---